

## **ЗАВХАН АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2020 ОНЫ 09 ДҮГЭЭР САРЫН МЭДЭЭ**

### **Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар**

#### **1.1.Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын үйл ажиллагааны талаарх мэдээлэл:**

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлыг 1 удаа хийж, Тариалангийн бүс нутаг тогтоох тухай, Үндсэн хөрөнгө акталж данснаас хасах зөвшөөрөл олгох тухай, ИТХ-ын Тэргүүлэгчдийн ажлын албаны ажилтнуудын орон тоо, цалингийн санг батлах тухай, Сонсгол даргалагчийг томилон ажиллуулах тухай зэрэг асуудлуудыг хэлэлцэж шийдвэр гаргаж биелэлтийг хангуулахаар холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлж ажиллаж байна.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн ажиллах нийтлэг журмын төсөлд саналаа бичгээр гаргаж Монгол улсын Хууль зүйн яам, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах ажлын албанд хүргүүлсэн.

Улс төрийн хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх өдөр жил бүрийн 09 дүгээр сарын 10-нд тохиодог билээ. Энэ жил улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн гэгээн дурсгалыг хүндэтгэх өдөр 25 дахь жилдээ тохиож буй бөгөөд энэ өдрийн хүрээнд Завхан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Улиастай сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хамтран зохион байгуулж ажиллах үйл ажиллагааны төлөвлөгөө хөтөлбөрийг аймгийн ИТХ-ын даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

#### **1.2. Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаарх мэдээлэл:**

Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга Завхан аймагт 2020 оны 09 дүгээр сарын 16-ны өдөр ажиллалаа. “Алдарт эх” нэгдүгээр зэргийн одонгоор 11, Хоёрдугаар зэргийн одонгоор 216 нийтдээ 227 ээж хүртлээ.

Аймгийн иргэд хөдөлмөрчидтэй уулзалт зохион байгуулж, 2020 онд хэрэгжүүлсэн ажлын тайланг танилцуулж тэдэндтэй санал хүсэлт солилцлоо.

Төв номын сангийн эрхлэгч, Тосонцэнгэл сумын 2, 5 дугаар цэцэрлэгийн эрхлэгч, Улиастай сумын 7 дугаар цэцэрлэгийн эрхлэгч, Улиастай сумын Дэвшил ерөнхий боловсролын сургуулийн захирал, Тэс, Шилүүстэй, Ургамал сумдын ерөнхий боловсролын сургуулийн захирлын төсвийн шууд захирагчийн албан тушаалыг нөхөх тусгай шалгалтыг 2020 оны 09 дүгээр сарын 26-ны өдөр зохион байгуулж ажиллалаа. Тусгай шалгалтад 9 иргэн бүртгүүлж оролцон, амжилттай тэнцсэн байна.

Монгол Улс, Холбооны Бүгд Найрамдах Герман Улс хоорондын иж бүрэн түншлэлийн хүрээнд Монгол Улсад Суугаа Элчин сайд Ёорн Розенберг тэргүүтэй төлөөлөгчид 2020 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр Завхан аймагт айлчилж, Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн санхүүжилтээр хэрэгжиж буй “Түншлэлд суурилсан мэргэжлийн боловсрол” төслийн явцтай танилцаж, хамтын ажиллагааны талаар санал солилцлоо.

Хоёр улсын стратегийн түншлэлийн хүрээнд АНУ-ын Элчин сайдын Яамны Олон нийттэй харилцах албаны дарга Роберт Тейт Завхан аймагт ажиллалаа. Энэ үеэр аймгийн Засаг даргатай уулзаж Боловсрол, соёлын байгууллагын үйл ажиллагаатай танилцан АНУ-ын Засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөр, америкт суралцах боломжийн талаар мэдээллийг өгч, Америкт төгсөгчдийн холбоо, Education USA байгууллага хамтран ажиллалаа.

Завхан аймаг “Сайн малчин” дэд хөтөлбөр боловсруулан баталж дөрөв дэх жилдээ амжилттай хэрэгжүүлж байна. Тус хөтөлбөрийн хүрээнд жил бүр малчдын зөвлөгөөнөө зохион байгуулж, малчид, мал аж ахуйн салбарт тулгамдсан асуудлуудаа хэлэлцэж, харилцан туршлага солилцдог билээ. Энэ жилийн зөвлөгөөнийг 2020 оны есдүгээр сарын 17-19-ний өдрүүдэд Нэгдсэн Үндэстний байгууллагатай хамтран малчдынхаа орлогыг нэмэгдүүлэх, мал аж ахуйн салбарын үр ашгийг сайжруулах, малчдын нийгмийн хамгааллыг өргөжүүлэхэд чиглэсэн өргөн хүрээнд зохион байгуулж байна.

Мал аж ахуйн үйлдвэрлэлийн “Асуудал-Шийдэл” зөвлөгөөн, “Таван-Эрдэнэ” фестивалийн нээлт өнөөдөр “Морин туурайн хясаа”-нд болж аймгийн ИТХ-ын дарга Ц.Балхярваа, аймгийн Засаг дарга Д.Батсайхан, НҮБ-ын Монгол дахь Суурин зохицуулагч Тапан Мишра, НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын Суурин төлөөлөгч Винод Ахужа, НҮБ-ын Хүн амын сангийн Тэргүүн Каори Ишикава, Европын холбооноос Монгол улсад суугаа төлөөлөгчийн газрын хамтын ажиллагаа хариуцсан Захирал Пьер Ив-Люка, УИХ-ын гишүүн Б.Баярсайхан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа болон ХХААХҮЯ-ны төлөөлөл, 300 гаруй малчин оролцлоо.

### **Хоёр. Эдийн засаг, төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд:**

**2.1.Татвар төлөлтийн байдал:** Татварын орлогын төлөвлөгөө аймгийн дүнгээр 135.2 хувийн биелэлттэй, 7 тэр бум 526.7 сая төгрөгийн орлого оруулсаны цалин хөлс түүнтэй адилтгах орлого 51.7 хувь, нэмэгдсэн өртгийн албан татвар 5.3 хувь, татварын бус орлого 5.2 хувь, авто тээврийн албан татвар 3.1 хувь, бусад нэр төрөл 34.7 хувийг тус тус эзэлж байна. Нийт татварын орлогын бүрдүүлэлтийн 91.9 хувь буюу 6 тэрбум

919.2 сая төгрөгийг орон нутгийн орлого, 8.1 хувь буюу 607.5 сая төгрөгийг улсын төсвийн орлого бүрдүүлж байна.

Монгол банкны мэдээгээр эхний 8 сард гүйлгээнд 21 тэрбум 659.7 сая төгрөг, иргэдийн мөнгөн хадгаламжид 72.0 мянган иргэний 124.5 тэрбум төгрөг байгаа нь иргэдийн мөнгөн хадгаламж өнгөрсөн оны мөн үеэс 25.7 тэрбум төгрөгөөр өссөн байна. Аймгийн дүнгээр эхний 8 сард нийт олгосон зээлээс 161.5 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна. Үүнээс анхаарал хандуулах зээлийн үлдэгдэл 0.7 хувь, чанаргүй зээлийн үлдэгдэл 1.1 хувийг тус тус эзэлж байна.

### **Гурав. Хууль зүйн бодлогын хүрээнд:**

**3.1. Хууль хяналтын үйл ажиллагаа:** 2020 оны 9 дүгээр сарын байдлаар Засаг даргын үйл ажиллагааны-26, Боловсон хүчний захирамж-5 гарсан байна. Тухайлбал: Комисс томилох тухай, Хөрөнгө гаргах тухай, Ажлын хэсэг байгуулах тухай, Захирамж хүчингүй болгох тухай, Үнэлгээний хороо байгуулах тухай, Иргэнд газар өмчлүүлэх тухай, Эрх сэргээх тухай, Зөрчил арилгуулж захирамж хүчингүй болгох тухай, Ажлаас чөлөөлөх тухай, Ажилд томилох тухай, газар эзэмших эрх шилжүүлэх тухай, эзэмших, өмчлөх эрх олгох тухай, Итгэмжлэгдсэн төлөөлөгч томилох тухай, Урамшуулал олгох тухай, Эрх шилжүүлэн гүйцэтгүүлэх тухай гэх мэт захирамж гаргасан.

"АВЛИГЫН ЭРСДЭЛЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛЬ ТОГТООМЖ" сэдэвт дугуй ширээний хэлэлцүүлэгийг 2020 оны 09 дүгээр сарын 07-ны өдөр USAID-н санхүүжилтээр "Хөгжлийн шийдэл" ТББ-ийн хэрэгжүүлж буй BEST хөтөлбөр, АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР, Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэстэй тус тус хамтран зохион байгууллаа. Нийт-15 албан хаагчид уг хэлэлцүүлэгт оролцлоо.

"Сүүдэр бүү тусга" арга хэмжээний хүрээнд аймгийн Цагдаагийн газраас аймгийн Хөгжимт жүжгийн театртэй хамтран аймгийн төвийн зургаан багийн иргэдэд арга хэмжээг танилцуулан зурагт хуудас, санамж сэрэмжлүүлэг тарааж нээлттэй өдөрлөгийн арга хэмжээг зохион байгууллаа.

Тус хэлтэс нь Монгол улсын үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлт бусад хууль тогтоомжид орсон өөрчлөлтийн талаарх иргэдэд ойлгомжтой байдлаар постер бэлтгэн [zaw Khan.gov.mn](http://zaw Khan.gov.mn) сайтад үргэлжлүүлэн байршуулан ажиллаж байна. Одоогоор 20 постер бэлтгэн байршуулаад байна.

**3.2. Гэмт хэрэг, зөрчлийн талаарх мэдээлэл:** Аймгийн хэмжээгээр эхний 8 сарын байдлаар 184 гэмт хэрэг бүртгэгдсэнээс 29.9 хувийг иргэдийн эрх чөлөө эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг, 32.6 хувь нь бусдын өмчлөлийн эсрэг гэмт хэрэг, 37.5 хувийг

бусад гэмт хэрэг эзэлж, өнгөрсөн оны мөн үеэс нийт гэмт хэргийн тоо 15 буюу 8.9 хувиар өссөн байна.

Эхний 8 сард гэмт хэргийн улмаас 20 хүн нас барсан нь өнгөрсөн оны мөн үеэс 33.3 хувиар өссөн байна. Оны эхнээс өссөн дүнгээр 11513 зөрчил илрүүлж, 273 хүн эрүүлжигдэн, 204 хүн баривчлагдсан нь өнгөрсөн оны мөн үеэс зөрчил 617, баривчлагдсан хүн 5-аар тус тус өсч эрүүлжигдсэн хүн 25-аар буурсан байна.

**3.3. Архивын ажлын мэдээлэл:** Ашиглалтын хувь үүсгэх ажлын хүрээнд 3 хөмрөг, 4 данс, 44 хадгаламжийн нэгжийн 2304 хуудас баримтыг сканердаж, 3 хөмрөг 4 дансны 44 хадгаламжийн нэгж, 2304 хуудас баримтыг photoshop програмд засварлаж, 3 хөмрөг, 3 дансны 54 хадгаламжийн нэгж, 4187 хуудас баримтаас заалт 2790, хүний нэр 12925, газарзүйн нэр 2 шивж цахим хэлбэрт оруулж, 54 PDF холболт хийлээ.

2 хөмрөгийн 211 хадгаламжийн нэгж баримтанд иж бүрэн нягтлан шалгалт хийж, үдэж хавтаслан холбогдох акт үйлдэж, данс бүртгэлд оруулсан.

Давхардсан тоогоор 471 иргэн, 9 байгууллагын хүсэлтийг хүлээн авч 471 иргэнд 346 лавлагаа, тодорхойлолт, 441 хуулбар олгож төрийн үйлчилгээ үзүүллээ.

Архиваас үзүүлж буй лавлагаа үйлчилгээний мэдээлэл, Төрийн архивын хөмрөгийн жагсаалт, 287 хөмрөг үүсгэгчийн нэрийн өөрчлөлтийн мэдээллийг нэгтгэж Архивын ерөнхий газарт хүргүүлсэн. Баянтэс сумын ЗДТГ-ын 2000 оноос хойшхи архивын баримтын дансыг нягтлан шалгаж мэргэжил арга зүйгээр хангаж ажилласан.

**3.4. Онцгой байдал:** Аймгийн Онцгой комиссын хурлыг 2020 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн байдлаар Улиастай суманд Тарваган тахлын сэжигтэй тохиолдол илэрсэнтэй холбогдуулан 2 удаа хуралдаж, 21 шийдвэрийг гарган холбогдох арга хэмжээнүүдийг авч ажиллаж байна.

Монгол Улсын Шадар сайдын баталсан удирдамжийн хүрээнд биелэлтийн хяналт шалгалтыг боловсролын 26 байгууллага, Онцгой байдлын ерөнхий газрын даргын баталсан удирдамжийн төлөвлөгөөт бус шалгалтын хүрээнд аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй шингэрүүлсэн шатдаг хий хадгалдаг, борлуулдаг иргэн, аж ахуй нэгж, автомашин хийгээр цэнэглэх станц, хий түгээх 3 цэгүүдийн барилга байгууламжид хяналт шалгалт зохион явуулж. Нийт 36 зөрчил дутагдлыг илрүүлж газар дээр нь 6 зөрчлийг арилгуулсан.

Заавал биелүүлэх албан шаардлага 5, Мэдэгдэл 3, Шинжээч мэргэжилтний дүгнэлт 1, Зөрчлийн тэмдэглэл 3, Барилга байгууламжийн зураг төсөл 3 хянаж Ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт 2-ыг тус тус үйлдсэн байна.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний комисс, Цагдаагийн ерөнхий газрын дарга нарын баталсан Химийн хорт болон аюултай бодисын хадгалалт, тээвэрлэлт,

ашиглалтад хяналт шалгалт хийх “БОДИС-2020” нэгдсэн арга хэмжээний удирдамж, Онцгой байдлын ерөнхий газрын Гамшгийн шуурхай удирдлагын газрын даргын 6/1979 дүгээр үүргийн дагуу 09 дүгээр сарын 18-ны өдөр тус аймгийн Дөрвөлжин сумын Цогт багийн нутаг дэвсгэрт уул уурхайн олборлолт явуулж байгаа Баян-Айраг эксплоерейшн ХХК-д Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний комиссын гишүүн П.Оюунчимэг, ахлах референт Л.Дүгэрсүрэн, аймгийн Цагдаагийн газрын экологийн цагдаа цагдаагийн ахмад н.Нямтулга, Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагч Б.Цэдэндамба Онцгой байдлын газрын гамшгаас хамгаалах төлөвлөлт, бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн, гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч, дэд хурандаа Х.Баярсайхан нарын бүрэлдэхүүнтэй хяналт шалгалтыг зохион явуулж тайлан мэдээг Онцгой байдлын ерөнхий газрын Гамшгийн шуурхай удирдлагын газарт 09 дүгээр сарын 23-ны өдөр хүргүүлсэн.

Тайлант хугацаанд ОБЕГ-ын Шуурхай удирдлага зарлан мэдээлэх төвийн Холбоо зарлан мэдээлэл хариуцсан оператортай утсан холбоогоор 98 удаа, Хил залгаа Ховд, Увс, Баян-Өлгий аймгуудтай радио станцаар 105 цахим шуудангаар 210 удаа холбоонд орж, холбооны чанар байдлыг шалгаж, нөхцөл байдлын талаар мэдээлэл солилцсон.

#### **Дөрөв. Нийгмийн хөгжлийн бодлогын хүрээнд:**

**4.1.Боловсрол, соёлын чиглэлээр:** НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр Эрүүл Мэндийн Газартай хамтран, “Өсвөр үеийн сэтгэцийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлууд, зөвлөгөө өгөх арга зүй” сэдэвт сургалтыг 2020 оны 9 дүгээр сарын 23, 24-нд зохион байгуулж, ЕБ-ын сургуулийн нийгмийн ажилтан, эмч нийт 46 хүн хамрагдлаа.

Сургалтад СЭМҮТ-ийн дэд захирал, доктор н.Баярмаа Ерөнхий боловсролын сургуулийн эрүүл мэндийн сургалтын хөтөлбөрийн агуулга, сэтгэцийн эрүүл мэндийн боловсрол, бие, сэтгэц, нийгмийн хувьд эрүүл байх, биеийн, сэтгэл зүйн, сэтгэл хөдлөлийн, оюун санааны, бэлгийн, нийгмийн эрүүл мэндийн хэмжүүр, стресс түүнийг даван туулах аргууд, эерэг, сөрөг хэлбэр, стрессорууд, хам шинж, түүний илрэл, стрессийн бие махбод, нийгмийн, сэтгэл хөдлөлийн, төрх үйлийн, танин мэдэхүйн илрэл, стресс тайлах аргууд, аж төрөх буруу зан үйлээ өөрчлөх агуулгаар, тус төвийн сэтгэл засалч эмч, Орчлон сургуулийн сэтгэл зүйч Б.Жаргал “Хүний амьдралын хөгжлийн мөчлөг /8/, төрөлтийн эрэмбэ /4/, ээнэгшлийн онол /4/, хүүхдийн хүмүүжилд эрдэм мэдлэг, харилцааны чадвар, хөдөлмөр, соёлын гэсэн 4 үйл ажиллагаанд тэгш анхаарах, миний гэр бүлээсээ суралцдаг зүйлс, хүүхэдтэй харилцах аргууд, сургуулийн сэтгэл зүйчийн үүрэг, хүүхдийнхээ сэтгэл оюуныг хөгжүүлэхдээ асуух асуултын төрөл, эцэг эхчүүдэд зориулсан зөвлөгөө, сэтгэл зүйн тусламж үйлчилгээний талаарх ерөнхий

ойлголт зөвлөгөө, сэтгэл судлалын шинжлэх ухааны үндсэн ойлголтууд, сэтгэл зүйн тусламж авахаар ханддаг шалтгаан, сэтгэл зүйн тусламж үзүүлэх өрөө гэсэн асуудлын талаар тус тус мэдээлэл хийж, харилцан ярилцлаа.

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль, эрүүл мэндийн газар хамтран НҮБ-ын Хүүхдийн сангийн санхүүгийн дэмжлэгтэйгээр ерөнхий боловсролын сургуулийн эмч нарт “Өсвөр үеийн эрүүл мэнд, тулгамдсан асуудлууд ба шийдвэрлэх арга зам” сэдэвт сургалтыг 2020 оны 09 дүгээр сарын 26-28-нд зохион байгуулж, 21 эмч хамрагдлаа. Сургалтаар АШУУИС-ийн АУС-ийн Хүүхдийн анагаахын тэнхимийн багш доктор, дэд профессор Г.Эрдэнэтуяа, Эх барих эмэгтэйчүүдийн тэнхимийн багш АУ-ны доктор, дэд профессор Ж.Энхцэцэг нар “Өсвөр насны утга учир, нийгмийн эрүүл мэндийн асуудалд түүний хамаарал”, “Өсвөр насны нөхөн үржихүйн эрүүл мэнд-охид хөвгүүдийн бэлгийн бойжилтийн үнэлгээ, бэлгийн замын халдвар”, “Өсвөр үеийн эрүүл мэндийн ээлтэй үйлчилгээ”, “Өсвөр насны өсөлт хөгжил”, “Өсвөр үеийн сэтгэцийн эрүүл мэнд, архи тамхи, мансууруулах бодисын хэрэглээ”, “Өсвөр насны жирэмслэлтээс хамгаалах хэрэгслэлийн тохиромжтой байдал”, “Өсвөр насны архаг эмгэгүүд, сарын тэмдгийн хямрал, цус алдалт” сэдвийн хүрээнд мэдээлэл хийж, дадлага ажлаар сэдвүүдийн хүрээнд багаар хамтран ажиллалаа.

Малчдын 6 настны “Гэр өргөө”-ний багш нарт зориулсан “Зөв бичих зүй” сургалтыг 2020 оны 09 дүгээр сарын 18-19-нд зохион байгуулж, “ Гэр өргөө”-ний 20 багш хамрагдлаа. Сургалтаар:

Гээгдэх, гээгдэхгүй эгшгийн дүрэм

Тоглоомын аргаар хүүхдийг хөгжүүлэх арга зүй

Хүүхдийг унших, бичих, сонсох аргад хэрхэн сургах талаар мэдээлэл, дадлага ажил хослуулан зохион байгууллаа.

Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангах зорилгоор Монгол Улсын Засгийн газар, Нэгдсэн Үндэсний байгууллагын Хүүхдийн Сангийн 2017-2021 оны хамтарсан улс орны хөтөлбөрийн хүрээнд цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд эрүүл хоол, идэвхтэй дасгал хөдөлгөөний орчин бүхий жишиг загварыг орон нутагт бий болгох ажлын хүрээнд “Ерөнхий боловсролын сургуулийн тогооч нарын мэргэжил дээшлүүлэх” сургалтыг 2020 оны 9 сарын 21, 22-нд зохион байгууллаа.

Сургалтын эхний өдөр Улиастай сумын 5-р цэцэрлэг, ерөнхий боловсролын Чандмань-Эрдэнэ лаборатори сургуулийн удирдлага, нярав, нягтлан тогооч, эмч, бага боловсролын сургалтын менежер нарт хүүхдийн хоол тэжээлийн чанар хүртээмжийг сайжруулах арга зүйн сургалт, сургалтын 2 дахь өдөр нь ерөнхий боловсролын

сургуулийн тогооч нарт арга зүй дадлага ажлын сургалт зохион байгуулагдаж дараах чадварыг эзэмшсэн.

- Хүүхдийн хоол тэжээлийн илчлэг шимт бодис тооцож гаргах арга зүй
- Гал тогооны тоног төхөөрөмж, аюулгүй ажиллагааны дүрэм
- Тогооч нар хувийн ариун цэврийг ажлын байрны үед чанд баримтлан ажиллах, мөн ажлын хувцсыг зөв боловсон өмсөж ажиллах

**Дадлага ажлаар:**

- Бууцайны зутан хийх аргачлал
- Бифштекс хийх аргачлал
- Чангаазны шүүс бэлтгэх аргачлал
- Чацарганы шүүс бэлтгэх аргачлал
- Хүүхдийн хоолны иж бүрдэл хийж сурсан.

Багшийн мэргэжил дээшлүүлэх институтын захирлын 2020 оны 08 дугаар сарын 18 ны өдрийн 1/139 тоот албан бичгийн дагуу 2020 оны 08 дугаар сарын 24-нөөс 09 дүгээр сарын 24-нд ерөнхий боловсролын сургуулийн захирал, сургалтын менежер, цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйч, нийгмийн ажилтан, дотуур байрын багш нарыг цахим сургалтад хамруулж ажилтан албан хаагчид 100 хувь хамрагдсан байна.

Дэлхийн багш нарын 26 дахь өдөр, Монголын багш нарын 54 дэх өдрийг тохиолдуулан аймгийн багш нарын баярын хурал 2020 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр Л.Ванганы нэрэмжит Хөгжимт жүжгийн театрт зохион байгууллаа.

Баярын хуралд Аймгийн Засаг дарга Д.Батсайхан урилгаар оролцон мэндчилгээ дэвшүүлж, Улиастай сумын ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, Боловсрол, соёл урлагийн газрын мэргэжилтэн, ахмад мэргэжилтнүүд, их дээд сургууль, мэргэжлийн сургуулийн удирдах ажилтан, багш нар нийт 300 гаруй төлөөлөгч оролцлоо. Хөгжимт Жүжгийн Театрын уран бүтээлчид болон Улиастай сумын ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтнууд хамтран Баярын хүндэтгэлийн тоглолт тоглож үзүүллээ.

2019-2020 оны хичээлийн жилд ажил үйлсээрээ шалгарсан багш ажилтнуудад шагнал гардууллаа. Боловсролын тэргүүний ажилтан 42, жуух бичгээр 76 багш, ажилтан, аймгийн Хүндэт тэмдгээр 5, боловсрол, соёл урлагийн газрын арга зүйч багш тэмдгээр 73, ахлах багш тэмдгээр 36, багшийн алдар тэмдгээр 35 багш шагнагдлаа.

Аймгийн Засаг дарга “Сайн багш” дэд хөтөлбөрийн хүрээнд 2020 оны элсэлтийн ерөнхий шалгалтад 800 оноо авсан Улиастай сумын ерөнхий боловсролын Чандмань-

Эрдэнэ лаборатори сургуулийн Математикийн багш С.Сарангэрэл, ерөнхий боловсролын Дэвшил сургуулийн Нийгмийн ухааны багш Н.Гантулга нарыг тус бүр 800 мянган төгрөгөөр, элсэлтийн ерөнхий шалгалтын 10 судлагдахуунаар хамгийн өндөр оноо авсан 10 багшийг тус бүр 100 мянган төгрөгөөр шагнаж урамшууллаа.

Монгол хэлний тухай хууль, Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлиг, “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III”-ын зорилтыг хэрэгжүүлэх, Миний Монгол-2025 хөтөлбөрийн үр дүнг сайжруулах, хүүхэд гэр бүлтэйгээ хамтран үндэсний ёс заншил, өв уламжлалаасаа суралцан, гэр бүлийн таатай орчин бүрдүүлэх зорилгоор зохион байгуулагдсан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын нэрэмжит “Хос бичигтэн” аян 3 үе шаттайгаар амжилттай боллоо.

Аяны 1-р шатанд Завхан аймгийн 29-н ерөнхий боловсролын сургуулийн 322 багт 966 сурагч, эцэг эхчүүд хамрагдаж оролцогчдын бүтээлээр сум тус бүр “Үндэсний бичиг үсгийн баяр”-ын өдрийг угтсан үзэсгэлэн гаргаж /хорио цээрийн дэглэийн үе байсан тул/ зураг бичлэгийг цахимаар “Хос бичигтэн аян group” фэйсбүүк хуудсаар сурталчилж олон нийтэд хүргэсэн.

Аяны 2-р шатанд 144 багт нэгдүгээр шатны гэр бүлийн гурван хүн төрийн албан хаагч, мэргэжлийн бус багш, сурагч гэсэн 3 хүнийг багтаа элсүүлэн 864 оролцогч хамрагдаж дараагийн шатанд оролцох багийг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас томилогдсон ажлын хэсэг шалгаруулсан.

Тус аяны үр дүнг хамрах хүрээ улам бүр өргөжсөөр 3 дугаар шатны шалгаруулалтад оролцсон баг Зуны бүтээлч даалгаврын тайлан, /багийн гишүүн бүр нэг хүнд монгол бичиг заасан/ шилдэг нэг бүтээлээ ирүүлж шилдэгүүдээ тодруулаа. Шалгаруулалтад 23 багийн бүтээл тайлан ирснийг зохион байгуулах комисс шалгаруулж бүтээлийн үзэсгэлэн гаргаж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Ц.Балхярваа, аймгийн Засаг дарга Д.Батсайхан, аймгийн Боловсрол соёл, урлагийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Мөнхдэлгэр нар шагналыг гардуулав.

Бүтээлүүд маань ардын уламжлалт сурган хүмүүжүүлэх ухааныг илэрхийлсэн утга агуулга бүхий муутуу цаас, даавуу, эсгий зэрэг материал дээр оёмол, бичмэл, хатгамал, наамал хэлбэрээр өөрийн шинэ санааг илэрхийлсэн бичгийн чадвар маш сайжирсан ширүүн өрсөлдөөнтэй боллоо.

ТЭРГҮҮН БАЙРТ: Тосонцэнгэлийн сумын II сургуулийн Ч.Батцэнгэл багштай Г.Намуунцэцэг ахлагчтай “Бэхсийн үнэр” баг, Шагнал : Өргөмжлөл, 1.200.000 мянган төгрөг



ДЭД БАЙРТ: Улиастай сумын ЧЭЛС-ийн Б.Урангоо багштай Я.Анхзаяа ахлагчтай баг, Шагнал:Өргөмжлөл: 600.000 мянган төгрөг

ДЭД БАЙРТ: Улиастай сумын ЧЭЛС-ийн Мөнгөнсувд багштай Х.Сувд-Эрдэнэ ахлагч баг, Шагнал:Өргөмжлөл: 600.000 мянган төгрөг

ГУТГААР БАЙРТ: Их-Уул сумын Б.Билгүүн ахлагчтай “Тэнгэрийн зурлага” баг Шагнал:Өргөмжлөл: 300.000 мянган төгрөг

ГУТГААР БАЙРТ: Тосонцэнгэл сумын I сургуулийн Д. Мөнхцэнгэл багштай М.Хонгорзул ахлагчтай баг, Шагнал:Өргөмжлөл: 300.000 мянган төгрөг

ТУСГАЙ БАЙРТ:Улиастай сумын IV сургуулийн Юнрэндорж багштай Отгонтогтох ахлагчтай баг, Шагнал: Өргөмжлөл: 100.000 мянган төгрөгөөр тус тус шагнагдлаа.

### **СОЁЛ УРЛАГ:**

Соёл урлагийн ажилтны баярын өдрийг тохиолдуулан аймгийн соёл урлагийн ажилтнуудын чуулганыг 2020 оны 9 дүгээр сарын 11,12-ны өдрүүдэд Улиастай сумд “Соёл урлаг-шинэ нөхцөлд” уриан дор зохион байгуулж, соёл урлагийн төрийн болон төрийн бус байгууллагын 160 гаруй төлөөлөл оролцож, Боловсрол, соёл урлагийн газрын даргыг түр орлон гүйцэтгэгч Д.Мөнхдэлгэр “Завхан аймгийн соёл урлагийн салбарын өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал” сэдвээр илтгэл тавилаа.

Соёлын яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газартай хамтран хэрэгжүүлж буй “Соёлын цаг” нөлөөллийн аяныг Төв номын сан, Хөгжимт жүжгийн театр, аймгийн музей, сумдын соёлын төвүүд хамтран зохион байгуулж сум, багийн иргэдэд соёл урлагийн олон төрлийн үйлчилгээг хүргэх нэгдсэн төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.

Чуулганы хүрээнд гар бөмбөгийн нөхөрсөг тоглолт зохион байгуулагдаж, аймгийн Засаг дарга Д.Батсайхан, Боловсрол, соёл урлагийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Мөнхдэлгэр нар уригдан оролцож соёл урлагийн салбарын ажилтнуудад баярын мэндчилгээ хүргэлээ. Урилгаар Төрийн шагналт, Болор цомын эзэн яруу найрагч Ц.Бавуудорж, Болор цомын эзэн яруу найрагч Ю.Болдхуяг нар уран бүтээлийн дээжээ өргөн барьж, МУСТА дуучин Л.Нарантуяа, Н.Дашдэмбэрэл, О.Баянмөнх, Х.Батмэнд нар ая дуугаа өргөлөө.

Салбартаа үр бүтээлтэй, амжилт гарган ажиллаж байгаа ажилтнуудаа шагнаж урамшуулсан ба аймгийн хүндэт тэмдгээр 8, Монголын соёлын ажилтны “Соёлын түшиг” холбооны “Соёлын гавьяа” тэмдгээр 6, Монголын эмэгтэйчүүдийн холбооны шагналаар 4, Дорнын их яруу найрагч Б.Явуухулангийн 90 насны ойн хүндэт тэмдгээр 2, Соёл урлагийн салбарын тэргүүн шагнал “Соёл-Эрдэнэ” цул мөнгөн тэмдгээр 1, нийт 21 ажилтан, албан хаагч шагнагдлаа.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн “Номын баяр” тэмдэглэх тухай 2012 оны 158 дугаар зарлигийг хэрэгжүүлэх, ард иргэд, хүүхэд залуучуудыг номтой нөхөрлүүлэх, ном эрдмийг сурталчлах, хүүхэд залуучуудын сурах эрмэлзлэлд дэмжлэг үзүүлэх зорилгоор “Номын баяр-2020” арга хэмжээг “Хязгаар үгүй-Ном- сэтгэлгээний эрх чөлөө” уриан дор 2020 оны 09 дүгээр сарын 18-20-ны өдрүүдэд амжилттай зохион байгууллаа.

“Номын баяр-2020” үйл ажиллагааны хүрээнд “Аз хур” номын их дэлгүүртэй хамтран 25-72 хувийн хямдралтай номын худалдааг Улиастай сумд 2020 оны 9 сарын 17-нд, Тосонцэнгэл сумд 2020 оны 9 сарын 16-нд тус тус зохион байгуулсан нь ард иргэдийг соён гэгээрүүлэх, айл өрхийн номын санг баяжуулах, номтой нөхөрлөхөд чухал үүрэг гүйцэтгэсэн ба иргэд 400 нэр төрлийн арван мянга гаруй номын худалдан авалт хийсэн байна. Мөн Аз хур номын дэлгүүрээс сумдын номын санд тус бүр 100,0 мянган төгрөгний буюу 2,3 сая төгрөгний номын хандив өргөсөн байна.

Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгтэй хамтран хүүхэд багачуудыг номонд дуртай болгох, сэтгэлгээг хөгжүүлэх, багаар ажиллаж сургах зорилгоор сургуулийн бага ангийн суралцагчид болон цэцэрлэгийн ахлах бүлгийн хүүхдийн дунд үлгэрийн баатруудын дүрийг бүтээх, жүжигчилсэн тоглолт, аман хэлэлцүүлэг хийх, сургуулийн дунд, ахлах ангийн суралцагчдын дунд уран уншлагын уралдааныг зарлан дүгнэж, шалгарсан Улсын тэргүүний 1 дүгээр цэцэрлэгийн багачууд “Үлгэрийн баатрууд дуулж байна” сэдэвт жүжигчилсэн тоглолт, ЧЭЛС-ийн Номч клубийн суралцагчид Завхан аймгийн Их-Уул сумын харъяат Болор цомын эзэн яруу найрагч Баттулгын “Монгол бичиг минь үү зээ” мөн тус сургуулийн Бямбасүрэн багштай 12 дугаар ангийн суралцагчид Дорнын их яруу найрагч Бэгзийн Явуухулангийн “Хүлэг минь, шүлэг минь” шүлгүүдээр мэндчилгээ дэвшүүллээ.

“Номын баяр” нээлтийн арга хэмжээг 2020 оны 09 дүгээр сарын 19-ний өдөр Улиастай сумд Төв номын сан, сумдад соёлын төвүүд хариуцан зохион байгуулж, ард иргэд, хүүхэд залуучууд, төрийн болон төрийн бус соёлын байгууллагууд, ерөнхий боловсролын сургуулийн багш суралцагчид өргөнөөр оролцлоо.

Номын баярын нээлтийн үйл ажиллагааны үеэр Төв номын сангийн тасаг танхимууд өөрийн танхимын үйл ажиллагааг сурталчлан, шинэ номын үзэсгэлэн, Монгол бичгийн бүтээлийн үзэсгэлэн, Сурах бичгийн солилцоо худалдаа болон хандивын хайрцаг аялуулах зэрэг ажлуудыг зохион байгууллаа. Номын идэвхтэн уншигчдаа тодруулан Тэргүүний уншигч Д.Нацагдорж, Б.Явуухулан тэмдгээр шагнаан урамшууллаа.

Завхан аймгийн 23 сумын нийтийн номын сангууд “Номын баяр 2020” арга хэмжээний хүрээнд ард иргэд, хүүхэд залууст зориулан шинэ номын үзэсгэлэн, Завхан

нутгаас төрсөн зохиолч, яруу найрагчдын номын үзэсгэлэн, “Номын сайн нөхөр” жүжигчилсэн тоглолт, “Норовын намтар” жүжигчилсэн тоглолт, “Номын сар” аян, Шилдэг уншигч шалгаруулах үйл ажиллагаа зэргийг амжилттай зохион байгуулан Тэргүүний уншигчдаа шалгаруулан нийт 100 гаруй идэвхтэн уншигчдаа шагнаж урамшуулсан байна.

“Номын баяр” арга хэмжээнд 10000 гаруй ард иргэд, хүүхэд залуучууд шууд оролцсон бөгөөд үүссэн нөхцөл байдалтай холбоотойгоор зохион байгуулсан бүхий л үйл ажиллагааг орон нутгийн хэвлэл, мэдээллийн хэрэгслүүд болон цахимаар сурталчлан ажиллалаа.

**4.2.Эрүүл мэнд, спортын чиглэлээр:** Аймгийн хэмжээнд эхний VIII сард 910 эх амаржиж, амьд төрсөн хүүхэд 916 болсон нь, өмнөх оны мөн үеэс амаржсан эх (3.3%)-аар, амьд төрсөн хүүхэд (3.1%)-аар буурсан байна.

Халдварт өвчнөөр өвчлөгчид эхний VIII сард 377 болж, өмнөх оны мөн үеэс 46 буюу (10.9%)-аар буурсан байна.

Эхний VIII сард 11.6 мянган өвчтөнийг 81.8 мянган ор хоногоор хэвтүүлж эмчлэн, 209.5 мянган хүнд амбулатороор үйлчилж, 979 жирэмсэн эхийг шинээр хяналтанд авчээ.

ШУГТЭ-ийн зүрхний гажигийн багийн эмч нар, аймгийн Нэгдсэн эмнэлгийн зүрхний эмч нартай хамтран сум, өрхийн 25 эмчид “Зүрхний төрөлхийн гажгуудын оношилгоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэлт” “Хэрэх өвчний оношилгоо, эмчилгээ” “MNКардио”, “MNStrike” программын талаарх 1 өдрийн сургалтыг зохион байгууллаа.

НҮБ-н Хүүхдийн сангийн санхүүжилтээр хэрэгжиж буй “Хүүхдэд ээлтэй орон нутаг хөтөлбөрийн хүрээнд “0-5 хүртэлх насны хүүхдийг зуны сувилалд” хамруулах төслийг харьяа эрүүл мэндийн 15 байгууллага дээр хэрэгжүүлэн, нийт 675 хүүхдийг сувилж, ар гэр, асран хамгаалагч нарт сургалт хийгдсэн байна.

#### **Нийгмийн даатгал, халамж**

Аймгийн хэмжээгээр нийгмийн даатгалын сангаас эхний 8 сард 11.6 мянган хүнд 37.0 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж олгож, 11.6 тэрбум төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг төвлөрүүлсэн байна.

Эхний хагас жилд 71684 хүн нийгмийн даатгалд хамрагдсаны 66985 буюу 93.4 хувь нь төсөвт байгууллага, ААНэгж байгууллагын даатгуулагч, 4699 иргэн буюу 6.6 хувь нь сайн дурын даатгалд хамрагдсан байна.

Сангуудаар авч үзвэл: тэтгэврийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөг 20.6 хувиар, тэтгэмжийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөг 39.4 хувиар, ҮОМШӨ

сангийн орлогын төлөвлөгөөг 23.5 хувиар, ажилгүйдлийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөө 71.3 хувиар тус тус давуулан биелүүлсэн байна.

Тэтгэвэрийн сангийн зарлага 33979.1 сая төгрөгт, Тэтгэмжийн сангийн зарлага 2530.2 сая төгрөг, ҮОМШӨ-ний зарлага 100.2 сая төгрөг, ажилгүйдлийн даатгалын сангаас 398.8 сая төгрөг тус тус зарцуулж нийт 37008.3 сая төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, даатгалыг олгосон байна.

Халамжийн сангийн үйл ажиллагааны эхний хагас жилийн мэдээгээр Халамжийн тэтгэвэр 1506 хүнд 3117.8 сая төгрөг, нөхцөлд мөнгөн тэтгэмж, нийгмийн халамжийн үйлчилгээ болон хөнгөлөлт 26109 хүнд 4046.9 сая төгрөг нийт 27615 хүнд 7164.7 сая төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлтийг үзүүлсэн байна.

### **Хөдөлмөр эрхлэлт**

Аймгийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт бүртгүүлсэн ажил идэвхитэй хайж байгаа ажилгүй хүний тоо 506 болж, өнгөрсөн оны мөн үеэс 15.2 хувиар буюу 91 хүнээр буурсан байна. Аймгийн хэмжээнд 258 эмэгтэй ажил идэвхитэй хайж байгаа нь ажилгүйчүүдийн 51.0 хувийг эзэлж байна.

2020 оны 8 сарын байдлаар бүртгүүлсэн, ажил идэвхитэй хайж байгаа ажилгүйчүүдийн тоо өмнөх 5 жилийн дунджаас 15.2 хувиар буюу 310 хүнээр буурсан байна.

**Тав. Хөдөө аж ахуйн бодлогын хүрээнд:** 9 сарын 1-ний байдлаар 107.8 тн төмс, 182.8 тн хүнсний ногоо, 2631.0 тн хадлан, 15.0 тн гар тэжээл, 111.0 тн тэжээлийн ургамал тус тус хураан аваад байна. Ургац хураалтын мэдээг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулхад төмс 142.6 тн буюу 56.9 хувиар, хүнсний ногоо 54.3 тн буюу 22.9 хувиар, гар тэжээл 11.0 тн буюу 42.0 хувиар, байгалийн хадлан 2128.4 тн буюу 44.7 хувиар тус тус буурч тэжээлийн ургамал 48.0 тн буюу 76.2 хувиар өссөн байна.

Намрын ногоон өдрүүд нэгдсэн арга хэмжээ 2020.09.15–2020.09.21-ний хооронд зохион байгуулагдаж “Мөнхөд мандаг ХХК” оролцож 2 сая төгрөгний борлуулалт хийсэн байна.

“Таван эрдэнэ фестиваль”-ийн хүрээнд зохион байгуулагдсан брэнд бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдаанд үндэсний 4 үйлдвэрийн 36 нэр төрлийн бүтээгдэхүүн оролцож 39,0 сая төгрөгний борлуулалт, 22 сумын 153 нэр төрлийн бүтээгдэхүүн оролцож 17 сая төгрөгний борлуулалт, эцэг малын үзэсгэлэн худалдааг зохион байгуулж, 18 сум, 7 аж ахуйн нэгжийн 135 мал оролцож, 64 эцэг мал худалдаалагдаж, 16,0 сая төгрөгийн борлуулалт хийгдсэн.

Азийн хөгжлийн банкны хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн нэмэлт санхүүжилт төслөөс санхүүжүүлэн “Сүү бэлтгэхэд баримтлах зохистой дадал, эрүүл ахуй ариун

цэврийн шаардлага хангасан сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэх” сэдэвт сургалтанд хамруулахаар 5 сумын 5 иргэний материалыг холбогдох газарт хүргүүлсэн.

Сум хөгжүүлэх сангаас 126 аж ахуйн нэгж, иргэнд 561.8 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгосон.

Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн хөнгөлөлттэй зээлийн төсөл сонгон шалгаруулах дэд хороо хуралдаж тэргүүн ээлжинд 479.19 сая төгрөгийн 5 төсөл, эх үүсвэр үлдсэн, нэмэгдсэн тохиолдолд 451.0 сая төгрөгийн 6 төслийг санхүүжүүлэхээр аймгийн Засаг даргын 2020 оны А/358 дугаар захирамжаар баталгаажуулан Жижиг, дунд үйлдвэрийн газар хүргүүлсэн.

2020 оны ноосны урамшуулалд хонины ноос 1,6 мянган тн, тэмээний ноос 6,7 тн-ыг үндэсний үйлдвэрт тушаасан падаан тулгалтыг 24 сумаар хийлээ.

Шинээр бүртгэл мэдээллийн санг үүсгэж Дөрвөлжин, Эрдэнэхайрхан сум болон цөм сүргийн салбарын 5,0 мянган малыг оруулах ажлыг хийсэн.

**Зургаа. Байгаль орчин, үйлдвэрлэл, үйлчилгээ, дэд бүтцийн салбарын бодлогын хүрээнд:**

**6.1.Байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр:** Дөрвөлжин суманд үйл ажиллагаа явуулж буй “Баян айраг” ХХК Баян бор толгойд хайгуулын ажлыг явуулж байгаа ба “Монгол ус” ТӨҮГ-с гаргасан ус ашиглуулах дүгнэлтэд тусгагдсан ашиглалтын талбайгаас гарсан шүүрлийн усыг ашиглаж байсан ба ХНЗГСГЗ-ны ус ашиглуулах дүгнэлтэд энэ талаар тусгагдаагүй байна. Цаашид шүүрлийн усыг хайгуулын ажилд ашиглах зөвшөөрлийг холбогдох байгуулагуудаас авч ажиллах зөвлөмжийг өгч ажиллалаа.

Эрдэнэхайрхан сумын Мухартын голын эхрүү аялагчид ихээр өгсөж элсийг нураан усны ундрага багасаж байна гэсэн сум орон нутгийн иргэдээс ирсэн санал гомдлын дагуу Мухартын голын эхийн хэмжилтийг хийж усны түвшинг хэмжлээ. Өмнөх онуудын усны түвшинтэй харьцуулж холбогдох яаманд хүргүүлэхээр ажиллаж байна.

“Нөхөн сэргээлт 2020” арга хэмжээний дагуу Завхан аймгийн нутагт байгаа уул, уурхай, хайгуулын ажил явуулж байгаа аж ахуй нэгжүүдийн уул уурхайн улмаас эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн талбайн нөхөн сэргээлтийн ажлыг хүлээж авлаа.

Уг ажлын хүрээнд Завханмандал сумын “Шувуун хар уул” ХХК, Ургамал сумын “Түүчээ тэрэг” ХХК, “Форс голд майннинг” ХХК, Дөрвөлжин сумын “Баян айраг” ХХК –ны ашиглалтын талбайн эвдэрсэн газрын талбайг хэмжиж, нөхөн сэргээлтийг үзэж танилцлаа.

Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Аялал жуулчлалын үйлчилгээний чанарыг сайжруулах, хөдөлмөр эрхлэх насны ажилгүй иргэдэд мэргэжил олгох замаар

ажлын байраар хангах, тогтвортой амьжиргааг бий болгох зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Тогооч, Зөөгч, Бариста, Бартендер, Өрөөний болон гэрийн үйлчлэгч, Угаалгын ажилтан, Зочин хүлээн авагч, Хаалгач ачаа зөөгч, Аяллын жолооч, Хөтөч тайлбарлагч мэргэжлүүдээр “Зочлох үйлчилгээний төрөлжсөн сургалт”-ыг Завхан аймагт 2020-оны 9 дүгээр сарын 28-наас 10 дугаар сарын 02-ны хооронд 5 хоногийн мэргэшүүлэх сургалтыг амжилттай зохион байгууллаа.

Аймгийн засаг даргын үйл ажиллаганы хөтөлбөрт тусгагдсан өөрийн эзэмшлийн болон нийтийн эзэмшлийн талбайгаа зүлэгжүүлэх, мод тарих аж ахуй нэгж, иргэдийн санал санаачлагыг дэмжин, ногоон байгууламжийн хэмжээг 2 дахин нэмэгдүүлэх зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд Донойн нисэх онгоцны буудлын авто зам дагуу мод тарих ажлыг хийж гүйцэтгэсэн боловч мал бэлчээрлэлт тарьцын амьдралт, өсөлтөнд сөргөөр нөлөөлж энэ жилийн амьдралт 30 хувьтай байна.

Иймд мод тарьсан талбайг малын нөлөөллөөс хамгаалах шаардлага гарсан тул намрын нөхөн тарилт, хайс хамгаалалтыг сайжруулах ажлыг хийж гүйцэтгэлээ.

**6.2. Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр:** Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл эхний 8 сарын байдлаар оны үнээр 14 тэрбум 232.0 сая төгрөг болж, өнгөрсөн оноос 8.2 хувиар буюу 1 тэрбум 277.7 сая төгрөгөөр буурч, нийт үйлдвэрлэлээс ААНэгжийн үйлдвэрлэл нь 11 тэр бум 824.8 сая төгрөг, иргэдийн үйлдвэрлэл нь 2 тэрбум 407.2 сая төгрөг болсон байна.

Үйлдвэрлэлд цахилгаан, дулаан, усан хангамжийн үйлдвэрлэл 42.2 хувийг, хүнсний үйлдвэрлэл 20.2 хувь, боловсруулсан мах 20.3 хувь, хувцас үйлдвэрлэл 8.1 хувь, модон эдлэл үйлдвэрлэл 3.5 хувь, эсгий эдлэл үйлдвэрлэл 0.7 хувь, бусад үйлдвэрлэл 5.0 хувийг тус тус эзэлж байна.

**6.3. Дэд бүтцийн чиглэлээр:** Боловсрол, шинжлэх ухааны салбарын хөрөнгө оруулалтын мэдээллийг бүртгэх, мэдээллийн сан үүсгэх зорилгоор БШУЯ-ны [investment.edu.mn](http://investment.edu.mn) дотоод цахим системийг хөгжүүлж буй бөгөөд уг системд манай аймагт Боловсрол шинжлэх ухааны яамны хөрөнгө оруулалтаар баригдаж байгаа цэцэрлэгийн-5, хичээлийн байрны барилга-5, дотуур байрны барилга-1, их засвар-4 барилгын ажлын мэдээг оруулж ажилласан.

Мөн соёлын яамны хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа 10 барилга угсралт их засварын ажлын мэдээг [bd.enkhee@gmail.com](mailto:bd.enkhee@gmail.com) хаяг руу зураг болон хүснэгтэн тайланг хүргүүлсэн.

Он дамжин баригдах барилгаас 2020 оны 9-р сарын байдлаар Их-Уул сумын 640 хүүхдийн хичээлийн байр, спорт заал, Тосонцэнгэл сумын 640 хүүхдийн хичээлийн байр, Идэр сумын 200 хүний суудалтай соёлын төв, Баянтэс сумын 300 хүний

суудалтай соёлын төв, 100 хүүхдийн цэцэрлэг, Эрдэнэхайрхан сумын ЗДТГ, Улиастай сумын 2-р сургуулийн 640 хүүхдийн хичээлийн байр, спорт заал, Аймгийн МХГ-ын конторын барилга, 800 хүний суудалтай ХЖТ, Улиастай сумын Баазын хэсгийн бохир усны ажил, Улиастай сумын Гудамж төсөл, Алдархаан сумын Сумын төвийн шинэчлэлт, Нисэх буудлын авто замын уулзвараас Алдархаан сумын төв хүртэлх 6.7 км хатуу хучилттай авто зам, 15 ортой ЭМТ-ийн барилгын ажлуудын барилга угсралтын ажил эхэлсэн, үе шатны ажилд хяналт тавин ажиллаж байна.

Жавхлант цогцолбор сургуулийн барилга гадна дотор өрлөг хийгдэж байна.

Улиастай сумын гудамж төслийн хүрээнд хийгдсэн хатуу хучилттай авто зам, гэрэлтүүлэг хийсэн байдал.

Баянтэс сумын 300 хүний суудалтай соёлын төв

Баянтэс сумын 100 хүүхдийн цэцэрлэгийн барилга

Амьгийн эрүүл мэндийн газрын барилгын засвар, Тосонцэнгэл сумын ЭМТ-ийн барилгын засвар, Цаг уурын өртөөний барилга, Идэр сумын Идэр гол, Отгон сум Халтарын гол, Чулуутын голд модон гүүр барих ажлыг хүлээн авах ажлыг зохион байгуулан ажилласан.

Тосонцэнгэл сумын 1-р сургуулийн засвар, Баянтэс сумын спорт заалны засвар, Баянхайрхан сумын 100 хүүхдийн цэцэрлэг, Сантмаргаз сумын соёлын төвийн барилгын засвар зэрэг барилгуудын гүйцэтгэлийг хянаж тайланг бичиж баталгаажуулсан.

Олон жилийн цэвдэг хөрстөй Нөмрөг, Түдэвтэй сумын соёлын төвийн барилга, Түдэвтэй сумын ЗДТГ-ын конторын барилга, Асгат сумын 75 хүүхдийн дотуур байрны барилгын угсралтын ажлуудыг эхлүүлээд байна.

Улиастай суманд баригдах дулааны станцын цахилгааны шугамын трассын дагуу инженер геологийн өрөмдлөгийн ажлыг “Тэсийн бүрд” ХХК-р хийлгүүлж, дээжийг “Эко Тех инженеринг” ХХК-нд хүргүүлээ.

Мөн он дамжин баригдаж байгаа гэрээт хугацаа дууссан барилгуудыг ажлаа эрчимжүүлэх талаар албан тоот хүргүүлж ажиллалаа.

Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн 67 км хатуу хучилттай авто замын угсралтын ажил 70%-тай хийгдэж байна. 2020 оны 09 дүгээр сарын 27-ны өдрөөс тус замын ажлын тээврийн хэрэгсэлийн хөдөлгөөнийг бүрэн хааж, Яруу сумын Хатавч, Нарийн

даваагаар тээврийн хэрэгсэлийн хөдөлгөөнийг явуулж байна. 2020 оны 10 дугаар сарын 10-ны өдөр тус замыг бүрэн нээж тээврийн хөдөлгөөнийг явуулах хугацаатай ажиллаж байна.

**ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**